ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК




# Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох заавarчилгаа

Худалдаа хөгжлийн банк



| | |
|---|---|
| ***Компанийн оноосон нэр, хаяг:*** | Худалдаа, хөгжлийн банк ХХК<br>(Энэхүү хурлаар компанийн дүрмийг баталж, Улсын бүртгэлд бүртгүүлснээр банк хувьцаат компани хэлбэртэй болно.)<br><br>Монгол Улс, Улаанбаатар хот, 14210, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө 19, Худалдаа, хөгжлийн банкны төв байр |
| ***Хуралд оролцох хэлбэр:*** | Хосолсон /танхим болон зайнаас/ |
| ***Хурал хуралдах өдөр, цаг:*** | 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 10 цаг 00 минутад |
| ***Хурал хуралдах газар:*** | Танхим: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2 дугаар хороо, Ерөнхий сайд Амарын гудамжинд байрлах Бэст Вестерн Премьер **Туушин** Зочид Буудлын “Соёмбо” танхим.<br>Зайнаас: investor.tdbm.mn цахим хаягаар. |
| ***Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гарах өдөр:*** | 2023 оны 6 дугаар сарын 19-ний өдөр |

# Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох хувьцаа эзэмшигчид хурлын материал болон холбогдох бичиг баримттай танилцах журам

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох хувьцаа эзэмшигчид дараах арга, хэлбэрээр хурлын материал болон холбогдох бичиг баримттай 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн танилцаж болно. Үүнд:

- Худалдаа, хөгжлийн банкны **investor.tdbm.mn** цахим хаягт хандан, хурлын материал хэсгээр дамжуулан танилцах;
- Өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанид хандан танилцах;
- 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрөөс 2023 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн хооронд Худалдаа, хөгжлийн банкны төв байранд ажлын өдрүүдийн 10:00-17:00 цагийн хооронд ирж, Хурал зохион байгуулах комисст мэдэгдэн танилцах боломжтой.



Хувьцаа эзэмшигч Та дараах аргуудын аль нэгээр хуралдаа оролцож санал өгөх боломжтой. Үүнд:

- **Танхимаар оролцох**
- **Зайнаас оролцох**
- **Урьдчилсан санал өгөх**

**Танхимаар оролцох:**

Хуралд танхимаар оролцох хувьцаа эзэмшигчид хурлын өдөр буюу 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 09:00 цагаас эхлэн 09:30 цаг хүртэл бүртгэлээ хийлгэж, танхимд нэвтэрсэн байна.

Хуралд танхимаар оролцох хувьцаа эзэмшигч нь,

Хувь хүн бол: Хүчин төгөлдөр иргэний үнэмлэх эсхүл гадаад паспортыг шалгуулан танхимд нэвтэрнэ. Хувьцаа эзэмшигч өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичгээр олгож, нотариатаар гэрчлүүлсэн байна. Итгэмжлэгдсэн төлөөлөгч нь хүчин төгөлдөр иргэний үнэмлэх, эсхүл гадаад паспортыг шалгуулан нэвтэрнэ.

Хуулийн этгээд бол: Хуулийн этгээдийг төлөөлөн хуралд оролцож буй этгээд нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар,  хувьцаа эзэмшигчийн хуралд төлөөлөн оролцох эрх бүхий этгээдийг томилсон шийдвэр (Хувьцаа эзэмшигчийн хурлын шийдвэр эсхүл Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тогтоол)-ийн эх хувь эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг Тооллогын комисст хүлээлгэн өгч, өөрийн хүчин төгөлдөр иргэний үнэмлэх, эсхүл гадаад паспортыг шалгуулан танхимд нэвтэрнэ.

Хуралд танхимаар оролцох хувьцаа эзэмшигчид нь 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн 2023 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 12:00 цаг хүртэл хүртэл хугацаанд Худалдаа, хөгжлийн банкны investor.tdbm.mn цахим хаягаар урьдчилан бүртгүүлж QR код авч, тус QR кодыг шалгуулан хурлын танхимд дараалалгүй нэвтрэх боломжтой.

# Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд урьдчилсан санал өгөх оролцох заавар

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд урьдчилан санал хүргүүлэх хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрөөс 2023 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 12:00 цаг хүртэл Худалдаа, хөгжлийн банкны төв байранд Тооллогын комисс хүлээн авна.

Худалдаа, хөгжлийн банкны **investor.tdbm.mn** цахим хаягт хандан, Саналын хуудас хэсгээр дамжуулан "Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын саналын хуудас"-ыг татаж авах боломжтой.

Та саналын хуудсыг бөглөхдөө "Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын саналын хуудас" дахь зааварчилгаатай сайтар танилцана уу.



## Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд зайнаас оролцох заавар

**Цахимаар оролцох:**

- Хуралд зайнаас оролцох хувьцаа эзэмшигчид 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн 2023 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 12:00 цаг хүртэл Худалдаа, хөгжлийн банкны **investor.tdbm.mn** цахим хуудсанд нийтлэгдсэн дараах зааврын дагуу цахимаар бүртгүүлж, бүртгэлээ баталгаажуулна.
- Цахимаар бүртгүүлж, бүртгэлээ баталгаажуулсан хувьцаа эзэмшигчид нь 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 09:00 - 09:30 цаг хүртэл цахим бүртгэлийн дагуу бүртгүүлсэн цахим хаягт хүргүүлсэн код, зааврын дагуу хуралд цахимаар оролцож, саналаа өгнө.

# Хуралд бүртгүүлэх

Худалдаа, хөгжлийн банкны хувьцаа эзэмшигчид нь https://investor.tdbm.mn/ сайт руу орж мэдээ, мэдээлэлтэй танилцах боломжтой. Хувьцаа эзэмшигчдийн хуралд бүртгүүлэхдээ тус сайтын **“Хуралд бүртгүүлэх”** товчийг даран орно.



Хувьцаа эзэмшигч нь иргэн бол **ХУВЬ ХҮН** сонголтыг сонгон **Регистрийн дугаараа** оруулан **“ДАН нэвтрэх”** товчийг дарна.



Танилт нэвтрэлтийн систем болох **“ДАН систем”**-рүү та банкны эрхээр болон доорх зурагт үзүүлсэнчлэн өөрийн боломжит хувилбарыг сонгон орно.



Танилт нэвтрэлтийн систем нь таны **“Иргэний үнэмлэхний мэдээллээр”** баталгаажуулалт хийгдэх тул доорх дэлгэц дуудагдаж та **“ЗӨВШӨӨРӨХ”** товч дарсанаар баталгаажуулалтын хэсэг амжилттай хийгдэнэ.



Хувьцаа эзэмшигчдийн хурлын урилга хүлээн авах албан ёсны **И-мэйл хаяг** болон **Гар утасны дугаараа** оруулан **Хуралд оролцох хэлбэрээ** сонгож, **“Хүсэлт илгээх”** товч дарж бүртгэлээ илгээнэ.



Таны хүсэлт амжилттай илгээгдсэн тохиолдолд дараах дэлгэц гарах бөгөөд таны илгээсэн холбогдох хаягаар хувьцаа эзэмшигчдийн хурлын урилгыг илгээх болно.



Хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол **БАЙГУУЛЛАГА** сонголтыг сонгон **Байгууллагын регистрийн дугаар** болон **итгэмжлэгдсэн төлөөлөгчийн регистрийн дугаараа** оруулан **“ДАН нэвтрэх”** товчийг дарна.



Танилт нэвтрэлтийн систем болох **“ДАН систем”**-рүү та банкны эрхээр болон доорх зурагт үзүүлсэнчлэн өөрийн боломжит хувилбарыг сонгон орно.



Танилт нэвтрэлтийн систем нь таны **“Иргэний үнэмлэхний мэдээллээр”** баталгаажуулалт хийгдэх тул доорх дэлгэц дуудагдаж, та **“ЗӨВШӨӨРӨХ”** товч дарсанаар баталгаажуулалтын хэсэг амжилттай хийгдэнэ.



**Итгэмжлэл** болон **Нэмэлт файлаа** хавсарган хувьцаа эзэмшигчдийн хурлын урилга хүлээн авах албан ёсны **И-мэйл хаяг** болон **Гар утасны дугаараа** оруулан **Хуралд оролцох хэлбэрээ** сонгож, **“Хүсэлт илгээх”** товч дарж бүртгэлээ илгээнэ.



Таны хүсэлт амжилттай илгээгдсэн тохиолдолд дараах дэлгэц гарах бөгөөд таны илгээсэн холбогдох хаягаар хувьцаа эзэмшигчдийн хурлын урилгыг илгээх болно.



Хурал оролцох хэлбэрээ **“Цахим”** –аар гэж сонгосон тохиолдолд таны холбогдох хаягаар баталгаажуулах нэг удаагийн нууц үг болон **“Zoom”** программын мэдээллийг илгээх болно.

zoom

Join a Meeting

Meeting ID or Personal Link Name

Join

# Цахим саналын хуудас

Хуралд оролцох хэлбэрээ **“Цахим”** –аар гэж сонгосон тохиолдолд таны холбогдох хаягаар илгээсэн **“Microsoft Forms”** линкээр орж цахимаар саналын хуудсыг бөглөн илгээнэ.

Microsoft Forms



ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК




## Хөгжилд хамтдаа